

ШҮҮХИЙН ХЭРГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ УДИРДЛАГЫН

МЭДЭЭ

2023 ОН 07 САР

№30

“ Шүүхийн ерөнхий зөвлөлийн Мэдээллийн технологийн газрын Хэргийн хөдөлгөөний удирдлагын хэлтэс **2023** оны **07** дугаар сарын хэргийн хөдөлгөөний мэдээг нэгтгэн, улсын хэмжээн дэх эрүү, иргэн, захиргааны хэргийн анхан шатны шүүхүүдийн хэргийн хөдөлгөөний судалгааг танилцуулж байна. ”

ХҮЛЭЭН АВСАН ХЭРЭГ, НЭХЭМЖЛЭЛ



2023.07.01-2023.07.31-ний өдрийн байдлаар Улсын хэмжээн дэх анхан шатны шүүхүүд нийт **4814** хэрэг, нэхэмжлэл

хүлээн авснаас эрүүгийн **986** хэрэг, иргэний **3541** нэхэмжлэл, захиргааны **287** нэхэмжлэл хүлээн авсан байна.


ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН ХЭРЭГ



Улсын хэмжээнд нийт **3551** хэрэг хянан

шийдвэрлэснээс эрүүгийн **835** иргэний **2584**, захиргааны **132** хэрэг хянан шийдвэрлэсэн

2023 ОНЫ 7 САРЫН БАЙДЛААРХ АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ХҮЛЭЭН АВСАН ХЭРЭГ, НЭХЭМЖЛЭЛИЙН МЭДЭЭ



ЭРҮҮГИЙН ХЭРЭГ

Хүлээн авсан нийт хэрэг **986** шатны шүүх **472** **47.8%**

Дүүргийн анхан

ИРГЭНИЙ ХЭРЭГ

Хүлээн авсан нийт нэхэмжлэл **3541** шатны шүүх **2395** **67.6%**


Дүүргийн анхан

ЗАХИРГААНЫ ХЭРЭГ

Хүлээн авсан нийт нэхэмжлэл **287** захиргааны хэргийн анхан шатны шүүх **172** **59.9%**

Нийслэл дэх

АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ХҮЛЭЭН АВСАН ХЭРЭГ, НЭХЭМЖЛЭЛИЙН МЭДЭЭГ ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕИЙНХТЭЙ ХАРЬЦУУЛБАЛ



Улсын хэмжээнд анхан шатны шүүхийн нийт хүлээн авсан хэрэг, нэхэмжлэлийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад:

Эрүүгийн хэрэг 103 буюу 10.4 хувиар, Захиргааны нэхэмжлэл 48 буюу 16.7 хувиар өссөн, Иргэний нэхэмжлэл 223 буюу 5.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Дүүргийн анхан шатны шүүхүүдийн 2023 оны 07 дугаар сарын нэгдсэн тайлан мэдээнээс үзвэл Хан-Уул дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх 388 нэхэмжлэл, Баянзүрх дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 99 хэрэг, Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх 172 нэхэмжлэл хүлээн авсан нь хамгийн өндөр үзүүлэлттэй гарсан байна.

Харин Багахангай дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх 1 нэхэмжлэл, Багахангай дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 0 хэрэг хүлээн авсан нь бусад дүүргүүдтэй харьцуулахад бага үзүүлэлттэй байна.

Орон нутаг дахь анхан шатны шүүхүүдийн хувьд

Дархан-Уул аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх 104 нэхэмжлэл, Баянхонгор, Сүхбаатар аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 36 хэрэг, Ховд аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүх 24 нэхэмжлэл хүлээн авсан байгаа нь хамгийн өндөр үзүүлэлттэй байна.

Орхон аймаг дахь иргэний хэргийн анхан шатны шүүх 10, Өмнөговь аймаг дахь эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 6 хэрэг хүлээн авсан нь бусад аймгуудтай харьцуулахад бага үзүүлэлттэй байна.

Харин Говьсүмбэр, Дундговь аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүх хүлээн авсан нэхэмжлэл байхгүй


байхгүй байна.

Иргэний хэргийн шүүхийн хувьд хүлээн авсан нийт 3541 нэхэмжлэлийн 2395 буюу 67.6%-ийг Дүүргийн анхан шатны шүүхүүд хүлээн авсан байна.


Захиргааны хэргийн шүүхийн хувьд хүлээн авсан нийт 287 нэхэмжлэлийн 172 буюу 59.9%-ийг Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүх хүлээн авсан байна.

Эрүүгийн хэргийн шүүхийн хувьд хүлээн авсан нийт 986 хэргийн 472 буюу 47.8%-ийг Дүүргийн анхан шатны шүүхүүд хүлээн авсан байна.

2023 ОНЫ 7 САРЫН БАЙДЛААРХ АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН ХЭРГИЙН МЭДЭЭ



АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН ХЭРГИЙН МЭДЭЭГ ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕИЙНХТЭЙ ХАРЬЦУУЛБАЛ



Улсын хэмжээнд анхан шатны шүүхээр нийт хянан шийдвэрлэсэн хэргийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад:

Эрүүгийн хэрэг 47 буюу 5.3 хувиар, Иргэний хэрэг 95 буюу 3.5 хувиар буурсан, Захиргааны хэрэг 14 буюу 10.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

ХУГАЦАА ХЭТРЭЛТ

Улсын хэмжээнд хянан шийдвэрлэх ажиллагаанд нийт **12803** хэрэг байгаагаас **3525** хэрэг буюу **27.5%**-ийг хугацаа хэтэрсэн хэрэг эзэлж байна.

Иргэний хэргийн анхан шатны шүүхүүдийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байгаа **10814** хэргийн **3375** хэрэг буюу **31.2%**, Захиргааны хэргийн анхан шатны шүүхүүдийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байгаа **855** хэргийн **148** хэрэг буюу **17.3%**, Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүдийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байгаа **1134** хэргийн **2** хэрэг буюу **0.1%** нь тус тус хугацаа хэтрэлттэй байна.




12803 хэрэг

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд

3525

Хугацаа хэтэрсэн нь нийт хэргийн **27.5%**

ШҮҮХ ХУРАЛДААН ХОЙШИЛСОН БАЙДАЛ



Харин эрүүгийн хэргийн шүүхийн хувьд 1160 шүүх хурал товлон зарласнаас 400 шүүх хурал хойшилсон байна.

4794

Шүүх хуралдаан

1922

хойшилсон


НИЙТ ХУРЛЫН

40%

Иргэний хэргийн шүүхийн хувьд 3117 шүүх хурал товлон зарласнаас 1154 шүүх хурал хойшилсон байна.

Захиргааны хэргийн шүүхийн хувьд 517 шүүх хуралдаан товлон зарласнаас 368 шүүх хурал хойшилсон байна.

2023 ОНЫ 7 САРЫН БАЙДЛААРХ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД БАЙГАА ХЭРЭГТ ХУГАЦАА ХЭТРЭЛТТЭЙ ХЭРЭГ



7 ДУГААР САРЫН НЭГДСЭН МЭДЭЭ

Д/д	Төрөл	ЭРҮҮ			ИРГЭН			ЗАХИРГАА		
		НИЙСЛЭЛ	ОРОН НУТАГ	НИЙТ	НИЙСЛЭЛ	ОРОН НУТАГ	НИЙТ	НИЙСЛЭЛ	ОРОН НУТАГ	НИЙТ
1	Хүлээн авсан	472	514	986	2395	1146	3541	172	115	287
2	Хянан шийдвэрлэсэн	437	398	835	1450	1134	2584	39	93	132
3	ХХША-д	715	419	1134	8577	2237	10814	617	238	855
4	Хугацаа хэтэрсэн	1	1	2	3207	168	3375	112	36	148

«НЭЭЛТТЭЙ ШҮҮХ» ХЭВЛЭЛИЙН БАГА ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛЛАА.



«Нээлттэй шүүх» хэвлэлийн бага хурал 2023.07.26-ны өдөр зохион байгуулагдсан. Шүүхийн ерөнхий зөвлөлийн байрнаас 20 гаран хэвлэл мэдээллийн байгууллага «Нээлттэй шүүх» хэвлэлийн бага хурлыг сурвалжиллаа. Монгол Улсын шүүхийн 2023 оны эхний хагас жилийн шүүн таслах ажиллагааны нэгдсэн дүн мэдээг танилцуулав.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүгчийн хараат бус байдал, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах албаны дарга Х.Билгүнзаяа, Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн шүүхийн Тамгын газрын Хэргийн Хэргийн удирдлагын хэлтсийн дарга Б.Оч болон бусад шүүхийн олон нийттэй харилцах чиг үүрэгтэй албан хаагч нар

«ЦАГИЙН АЖИЛТАН» КОНТЕНТ ТӨСӨЛ



Шүүхийн ерөнхий зөвлөлөөс “Цагийн ажилтан” контент төслийн хамт олонтой хамтран шүүхэд хэрэг бүртгэх, хуваарилах, шүүх хуралдаан товлох, мэдээлэх, шүүгч шийдвэр гаргахдаа баримталдаг зарчим, шүүгч, өмгөөлөгч, прокурорын чиг үүрэг, шүүхийн ил тод, нээлттэй байдлын талаар хөндсөн дугаарыг олон нийтэд цацлаа.

Тус нэвтрүүлгээр шүүх нь хүний эрхийг хамгаалах, хөндөгдсөн эрхийг сэргээх зорилгод чиглэсэн үйл ажиллагаа эрхэлдэг болохыг олон нийтэд ойлгуулахыг зорьсон болно. Бүтэн нэвтрүүлгийг <https://youtu.be/6tTjERJd2F8> юутүб сувгаас хүлээн авна уу.